



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/307

Арвайхээр

□ Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах тухай □

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.б, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.18 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нэр бүхий 5 эмийн санд тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Цагдаагийн газар (О.Ганбат)-т тус тус даалгасугай.


ОРЛОГЧ



О. БАТЖАРГАЛ

011100683

Аймгийн Засаг даргын 2020 оны 07
дугаар сарын 21-ны өдрийн 1307 дугаар
захирамжийн хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ, ШИНЭЭР ОЛГОХ
ЭМИЙН САНГУУДЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

Д/д	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Олгох хугацаа	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	Мон Ургамал хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Арвайхээр сум	Сунгах	5 жил	
2	Өвөрхангай эм хангамж ханган нийлүүлэх төв	Эм ханган нийлүүлэх төв	Арвайхээр сум	Сунгах	5 жил	
3	Энх-Амар хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Хужирт сум	Сунгах	5 жил	
4	Дулаан Богдын тун хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Богд сум	Шинээр олгох	3 жил	
5	Болор шүүдэргэнэ хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Арвайхээр сум	Шинээр олгох	3 жил	